



1745.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2019.06.28 № 59/3039

тавай _____ -ны № _____ -т

Г АЛБА, НЭГЖ, НУТАГ ДЭВСГЭР
ХАРИУЦСАН ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА
НАР ТАНАА

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны
A/129 дүгээр тушаалаар баталсан "Цагдаагийн алба
хаагчийн ёс зүйн дүрэм", "Цагдаагийн алба хаагчийн
сахилгын дүрэм"-ийг хүргүүлэв.

Алба хаагч нартаа танилцуулж, сургалт явуулан
үйл ажиллагаандaa мөрдөж ажиллана уу.

Хавсралт 18 хуудастай.

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

Л.НЯМДАВАА

0913333



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 23-ний өдөр

Дугаар 4/129

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нэгдүгээр, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дүрмийг алба хаагчдаар судлуулж, мердүүлж ажиллахыг цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа П.Батбаатар/-д даалгасугай.
4. Энэ тушаал баталсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 598, 2014 оны 869 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
5. Тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

ХҮУЛБАР ҮНЭН

Захиргааны удирдлагын газрын дарга,
цагдаагийн хурандаа

Ө.ЭНХТӨР

П.Оростогоо



0901824

Цагдаагийн алба хаагчийн
2017 оны 96 дугаар сарын 23 -ны
өдрийн 10 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

УХГДЭЛЭЭ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЕС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цагдаагийн алба хаагчайас баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон, ёс зүйн зерчлэвэс урьдчилан сэргийлэх, алба хаагчийн нэр төрийг хамгаалахад энэ дурмийн зорилго оршино.

1.2. Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа нь шуурхай, тасралтгүй байж, хуулиа дээдлэн, шударга ёс, тэгш байдлыг ханган, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, ажил хэрэгч, соёлч, цагдаагийн алба хаагчийн нэр төр, алдар хүндийг ямагт өргөж, өөрийгөө хөгжүүлэн, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхийг эрхэмлэнз.

1.3. Энэ дурэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зерчил" гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зерчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.3.2. "ноцтой зерчил" гэж Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дурэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд тус бүр тодорхойлон заасан, цагдаагийн албаны нэр хүндийг гутаах, эд хөрөнгийн хохирол учруулах зэрэг эрх, ашиг сонирхолд нь нелөөлөхүйц серег үр дагаврыг санаатай буй болгосон, энэ дурэмд заасан зерчлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй үед 2 буюу түүнээс дээш зерчсөн үйлдэл, эс үйлдэхүйг.

1.4. Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан мэргжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зерчилд хамаарахгүй.

1.5. Цагдаагийн алба хаагч нь бусдын ёс зүйн хэм хэмжээг зерчсөн үйлдэл, эс үйлдэхүйг үл тэвчинэ.

Хоёр. Ес зүйн хэм хэмжээ

2.1. Хууль дээдлэх:

2.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хэм хэмжээний эрх зүйн акт, дээд шатны байгууллага, албан тушаалтын хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлах;

2.1.2. нийтээр хулээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг сахин мөрдөх;

2.1.3. албан үүргээ гүйцэтгэх явцдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг үл задруулах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө

ашиглахгүй байх, албан ёсны шийдвэр гарваагүй аливаа асуудлын талаар байр суурь илэрхийлэхгүй байх, зөвшееерелгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

2.2. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх:

2.2.1. хүнийг үндэс угсаа, хэл, арсын өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шутлэг, үзэл бодол, боловсрол, зруул мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

2.2.2. цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусдын эрхэнд хууль бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргахгүй байх;

2.2.3. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, хамтран ажиллаж байгаа алба хаагчтай адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, тэдний нэр тэр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх.

2.3. Шударгаар ажиллаж, амьдрах:

2.3.1. хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлэн ашигласан болон ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байх, хамтран ажиллаж байгаа алба хаагчид энэ талаар хууль ёсны шаардлага тавих;

2.3.2. цагдаагийн байгууллагын нэр тэр, алдар хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;

2.3.3. бусад байгууллага, хамтран ажиллаж байгаа алба хаагчийн албаны ажилд хүндэтгэлтэй хандаж, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нелөөлөхгүй, бусдад зуучлахгүй байх, харьяаллын бус хэрэг маргаанд оролцохгүй байх;

2.3.4. авлига, хээл хахууль авах, егех, зуучлахгүй байх;

2.3.5. албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр төрд харшилж болох болон өөрийн санхүү, здийн засгийн аливаа хэлцэл, хөрөнгө оруулалт, здийн засгийн бусад ашиг сонирхлоо хэрэгжиулэх үйл ажиллагаанд ашиглахгүй байх, зуучлахгүй байх;

2.3.6. албан тушаал, хуулиар олгогдсон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглахгүй байх, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан аливаа этгээдэд давуу байдал бий болгох, угсан тохирох, амлалт егех, шан харамж авах, үйлчилгээ, зээл авах, ийнхүү авахаар шахаж шаардах, ятгах, бусдад зуучлах, хуульд харш болзол тавих, далайлган сурдуулэх, бусдын өмч хөрөнгийг хувийн болон албан ажилд ашиглахгүй байх;

2.3.7. алба хаагчийн шалгаж байгаа мэдээ, мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлт нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүссч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх;

2.3.8. байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгслийг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх.

2.4. Ёс суртахуунтай байх:

2.4.1. өөрийн болон албаны нэр төрийг ариун байлгах, иргэдтэй соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцах, үл тоох, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргахгүй байх;

2.4.2. албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, ялгаварлан гадуурхах, эрхшээлдээ байлгах, басамжлан доромжлох, сурдуулэхгүй байх;

2.4.3.байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрийн арга хэмжээг зохион байгуулж оролцохгүй байх;

2.4.4.албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

2.4.5.цагдаагийн алба хаагч нь ажлын байранд мөрийтэй, бооцоотой тоглоом, иргэний хувьд хуулиар хориглосон тоглоом тоглох, зохион байгуулахад оролцохгүй байх;

2.4.6.ажлын байранд, ажлын цагаар, албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон цагдаагийн дүрэмт хувцастай согтууруулах ундаа хэрэглэх, хуулиар хориглосон газарт тамхи татахгүй байх;

2.4.7. Олон нийтийн газар, авто зам, гудамж талбайд бие засах, эсхүл нус цэр, шулс, тамхины иш, хог хаяхгүй байх;

2.4.8.согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

2.4.9.шалгаж байгаа өргөдөл, гомдол, хэрэг, маргааны оролцогчидтой хувийн харьцаанд орохгүй байх;

2.4.10.гэр бүл, үр хүүхдээз хайр, халамжтай байж, нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөх;

2.4.11.олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албаны мэдээ, мэдээлэл, цагдаагийн дүрэмт хувцастай зураг, санал, сэтгэгдэл оруулахгүй, ажлын цагаар хувийн асуудлаар цахим сүлжээнд орохгүй байх;

2.4.12.цагдаагийн дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй байх;

2.4.13.иргэдтэй маргалдах, хэл амаар доромжлох, зохисгүй үг хэллэг хэрэглэх, шивнэлдэх, инээлдэх, залхсан, эсвэл уцаарласан өнгөөр харьцах зэргээр зан харьцааны дутагдал гаргахыг цээрлэх;

2.4.14.удирдах албан тушаалтан алба хаагчидтай соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцах;

2.4.15.цагдаагийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харьцах.

2.5.Өөрийгөө хөгжүүлэх:

2.5.1.цагдаагийн алба хаагч нь өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшингээ дээшлүүлэх нь насан туршийн үйл явц гэж ухамсарлан ойлгож, бухий л боломж, бололцоог ашиглан өөрийгөө хөгжүүлж, өөрийн алдаа, дутагдлыг арилгахыг зэмзэлзэх бөгөөд дээд шатны удирдах албан тушаалтан дэмжлэг үзүүлнэ.

Гурав.Хариуцлага

3.1.Цагдаагийн алба хаагчийг ёс зүйн зөрчил гаргасан бол түүний эрхэлж байгаа албан тушаал, цол, ажилласан жилийг үл харгалзан шалгаж шийдвэрлэнэ.

3.2. Ёс зүйн зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Цагдаагийн албаны тухай хууль¹-ийн 81.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна.

3.3. Сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 81.6 дахь хэсэгт заасны дагуу ёс зүйн сургалтад хамрагдах үүрэгтэй.

3.4. Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн 82.1.1-д заасны дагуу албанаас хална.

3.5. Ёс зүйн зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн 81.9 дэх хэсэгт заасныг баримтлан, хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцож болно.

Дөрөв. Бусад

4.1. Ёс зүйн дурмийн хэрэгжилтэд цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нар өдөр тутам хяналт тавьж ажиллана.

4.2. Цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь энэхүү дурмийг алба хаагчид танилцуулан гарын үсэг зуруулж, жилийн эцэст үр дүнгийн гэрээгээр үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.3. Ёс зүйн хувьд бусдад үлгэр дурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагчийг дараах байдлаар урамшуулж болно:

4.3.1. хамт олны өмнө сайшааж хувийн хэрэгт тэмдэглэх;

4.3.2. цалинг үр дүнгээр нэмэх /тэтгэмж, мөнгөн урамшуулалт олгох/;

4.3.3. боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах эрх олгох;

4.3.4. цалинтай амралт, сувиланд хамруулах;

4.3.5. цагдаагийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох;

4.3.6. албан тушаал дэвшүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах.

--оо--

¹Төрийн мэдээлэл эмхэгтэл, 2017 он, №20

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2017 оны 06 дугаар сарын 23-ны
адрийн 06 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

УХГ0025

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН САХИЛГЫН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

1.1. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн зорилго нь цагдаагийн албаны хзвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сахилга, хариуцлагыг журамлан зохицуулах замаар тэдний эрх ашиг, цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндийг хамгаалахад оршино.

1.2. Цагдаагийн алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг цагдаагийн алба хаагчийн сахилга гэнэ.

1.3. Цагдаагийн алба хаагчийн сахилга нь энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг сахиж биелүүлснээр илэрхийлэгдэнэ.

1.4. Цагдаагийн алба хаагч өргөсөн тангарагтаа үнэнч байж, түүнийг ёсчлон биелүүлнэ.

1.5. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм /цаашид "Сахилгын дүрэм" гэнэ/ нь цагдаагийн алба хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, зарчим, сахилгын зерчлийн терел, хэлбэрийг тодорхойлж, сахилгын зөвлөгөөн хийх, шийтгэл оногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.6. Цагдаагийн алба хаагч бүр сахилгын дурмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

1.7. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнууд нь алба хаагчдад буруу үлгэр дуурайлал үзүүлэх, зохисгүй харьцах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

1.8. Алба хаагч нь үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хуулийн 4, Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг тус тус баримтална.

Хоёрдугаар зүйл. Сахин баримтлах хэм хэмжээ

2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний Цагдаагийн үйл ажиллагаанд холбогдох заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 онд баталсан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, Интерполоос баталсан дүрэм, журам, Монгол Улсын хууль тогтоомж, Цагдаагийн тангараг, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм,

Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон. Цагдаагийн байгууллагын хөдөлмөрийн дотоод буюу үйл ажиллагааны журам болон энэ дүрмийг алба хаагч бүр дагаж мердене.

2.2.Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангах эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн зөвлөмж, шийдвэрийг дагаж мердене.

Гуравдугаар зүйл.Сахилгын зөрчил

3.1.Энэ дүрмээр хориглож, шийтгэл ногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчил гэж үзсэн.

3.2.Алба хаагчийн гаргасан үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчил гэж үзсэн албан тушаалтан энэ тухай тэмдэглэл үйлдэж зөрчил гаргасан байж болох алба хаагчид заавал мэдэгдэж, хариу тайлбарыг авна. Албаны шалгалт явуулж сахилгын зөрчил үйлдэгдсэн эсэхийг тогтооно.

3.3.Зөрчил гаргасан нь тогтоогдсон бол зөрчлийн шалтгаан нехцелийг заавал судалж тогтоон байгууллагын удирдлагад танилцуулна.

Дөрөвдүгээр зүйл.Сахилгын зөрчлийн талаарх өргөдөл, гомдол

4.1.Алба хаагч сахилгын зөрчил гаргасан тухай өргөдөл, гомдлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн бол албаны шалгалт явуулна.

4.2.Албаны шалгалтыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд явуулна. Энэ хугацааны дотор Цагдаагийн байгууллагын дарга албаны шалгалт явуулах хугацааг тогтоож болно.

4.3.Өргөдөл, гомдлын мереөөр ямар арга хэмжээ авч, хэрхэн шийдвэрлэсэн талаар өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.

4.4.Цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгж нь сахилгын зөрчлийн талаарх өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар мэдээллийн сан үүсгэж, хетелне.

4.5.Гаргасан өргөдөл, гомдол нь үндэслэлгүй бөгөөд алба хаагчийг илт гүтгэсэн шинжтэй болох нь тогтоогдвол хуулийн дагуу харьяалах эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

Тавдугаар зүйл.Сахилгын зөрчлийг шалгаж тогтоох

5.1.Цагдаагийн төв байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг Аюулгүй байдал хариуцсан нэгж, бусад цагдаагийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын даргын томилсон албан тушаалтан хүлээн авч, албаны шалгалт явуулна.

5.2.Албаны шалгалт явуулж байгаа албан тушаалтан нь шууд нотлох баримт, үндэслэл бүхий мэдээ, мэдээлэл, бусад баримтад тулгуурлан сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх, гаргасан зөрчилд тохирсон шийтгэл оногдуулах санал гаргах зарчмыг баримтална.

5.3.Албаны шалгалт явуулсан алба хаагч нь холбогдох хууль тогтоомжийг үндэслэл болгон дараах саналыг гаргана:

5.3.1.сахилгын зөрчил биш бол гомдол гаргагч иргэнд хариу мэдэгдэх;

5.3.2.сахилгын шийтгэл оногдуулах санал гаргах;

5.3.3.гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

5.4.Алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхэд тухайн алба хаагчийн сахилгын зерчил гаргаагүй нь шагнах урамшуулах үндэслэл болно.

Зургаадугаар зүйл.Сахилгын шийтгэлийг хүндруулэх,
хөнгөрүүлэх нехцэл байдал

6.1.Сахилгын шийтгэл оногдуулахдаа зерчлийн шинж байдал, гэм буруугийн хэлбэр, хор уршиг, үр дагавар, анх буюу давтан үйлдсэн эсэх, шалтгаан нехцэл, зерчил гаргагчийн хувийн байдлыг харгалзан үзнэ.

6.2.Сахилгын зерчлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол зерчлийн хор уршиг, гэм буруугийн шинж байдлыг харгалзан сахилгын шийтгэлийг хүндруулж оногдуулна.

6.3.Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад сахилга, ёс зүйн зерчил давтан гаргасан нь хүндруулэх нехцэл байдал болно.

6.4.Сахилгын зерчил гаргасан алба хаагчийн буруугийн хэлбэр, буруугаа ухамсарласан байдал, ажлын зерэг үр дүн, ёс зүйн төлөвшил, байгуулсан гавьяя, шинээр санаачилсан ажил зэргийг үнэлж хөнгөрүүлэх нехцэл байдалд харгалзан үзэж болно.

6.5.Цагдаагийн албаны тухай хуулийн 81.9 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол алба хаагчид оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас өмне сахилгын шийтгэлгүйд тооцож болно.

6.6.Энэ дүрэмд заасныг зерчиж, сахилгын зерчлийн хор уршиг, шинж байдалд илт үл нийцэн, үндэслэлгүйгээр сахилгын шийтгэлийг хүндруулж, эсхүл хөнгөрүүлж оногдуулсан албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

Долдугаар зүйл.Сахилгын зерчилд ногдуулах
шийтгэл, хугацаа

7.1.Алба хаагч энэ дүрэмд заасан зерчил гаргасан нь тогтоогдвол Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулна.

7.2.Алба хаагч нь Авлигын эсрэг хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зерчлээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчсөн бол тухайн хуульд заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

7.3.Сахилгын шийтгэл оногдуулахдаа Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.4-26.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 81.8 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

7.4.Сахилгын зерчлийг илрүүлснээс хойш 1 сарын хугацааг тоолоходо тухайн алба хаагчийн сахилгын зерчил гаргасныг шийдвэр гаргах эрх бүхий цагдаагийн байгууллагын дарга олж мэдсэн буюу шалгалтын дүгнэлттэй танилцсан үеэс эхлэн тоолно.

7.5. Алба хаагч сахилгын шийтгэл оногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

**Наймдугаар зүйл. Сахилгын шийтгэл оногдуулах
эрх бүхий албан тушаалтан**

8.1. Алба хаагчийн гаргасан сахилгын зерчилд явуулсан албаны шалгалтын дүнг цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл эрх бүхий албан тушаалтан нь албаны шалгалтын дүнг үндэслэн шууд тушаал гаргаж сахилгын шийтгэл оногдуулж болно.

8.2. Цагдаагийн төв байгууллагын дарга нь Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

8.3. Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь цагдаагийн дунд, ахлах, дээд цолтой буюу офицер бүрэлдэхүүнээс гаргасан сахилгын зерчилд Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4.1, 81.4.2 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

8.4. Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь ахлагч цолтой буюу ахлагч бүрэлдэхүүнээс гаргасан сахилгын зерчилд Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4.1, 81.4.2, 81.4.4, 81.4.5 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

8.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тохиолдолд түүнээс гаргасан шийдвэрийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий цагдаагийн байгууллагын дарга сахилгын шийтгэл оногдуулах тухай тушаал гаргана.

Есдүгээр зүйл. Судалгаа, тайлан

9.1. Алба хаагчдаас сахилгын зерчил гаргуулахгүй байх зорилгоор буртгэгдэж шийдвэрлэгдсэн зерчилд судалгаа, дун шинжилгээ хийж, мэдээллийг харьяа нэгж, байгууллагуудад хургуулна.

9.2. Цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгж нь сахилга, ёс зүйн зерчлийн талаар хийсэн судалгаа, дун шинжилгээг настгэн боловсруулж эрх бүхий байгууллага, албан тушаалтан, олон нийтэд тайлагнана.

9.3. Судалгаа шинжилгээний дунг үндэслэн эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хамтран, алба хаагчдын гаргасан сахилгын зерчлийг бууруулах ажлыг зохион байгуулна.

Аравдугаар зүйл. Баримт үлдээх

10.1. Сахилгын шийтгэл хүлээсэн цагдаагийн алба хаагчийн хувийн хэрэгт тухайн шийтгэл оногдуулсан талаарх мэдээллийг оруулна.

10.2. Сахилгын зерчилтэй холбоотой албаны шалгалтын материалыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд хадгална.

**Арван нэгдүгээр зүйл. Сахилгын зөвлөгөөн хийж,
ур дунг тооцох**

11.1. Цагдаагийн байгууллага, нэгж нь улирал бүр сахилгын зөвлөгөөн хийж, холбогдох мэдээлэл /маягт 111, 111a/-ийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор,

жилийн эцсийн мэдээг 12 дугаар сарын 20-ны дотор цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгжид ирүүлнэ.

11.2. Сахилгын зөвлөгөөн нь тайлант хугацааны сахилгын байдлыг бүрэлдэхүүнд мэдээлэх, гарсан зерчлийг шинжлэн хэлэлцэх, сахилга, хариуцлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зэрээр алба хаагчийн төлөвшүүлд нелөөлөх, зерчлеес урьдчилан сэргийлэх, асуудлыг хамтын оролцоотойгоор шийдвэрлэх зорилготой.

Сахилгын зөвлөгөөнийг зорилгоо хангах аль ч арга, хэлбэрээр зохион байгуулж болно.

11.3. Цагдаагийн байгууллага, нэгж нь гарсан зерчлийн үндсэн шалтгаан, нөхцөлийг бүртгэж, арилгах арга хэмжээ авна.

Зерчлийн үндсэн шалтгаан, нөхцөлийг арилгахад төв болон бусад байгууллагын оролцоо, дэмжлэг шаардлагатай бол ямар шалтгаан, нөхцөл байгааг аль байгууллагын, ямар оролцоотойгоор хэрхэн шийдвэрлэх талаар саналаа мэдээлэлд хавсаргана.

11.4. Сахилгын зөвлөгөөний мэдээлэлд сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, зерчлийг бууруулах, зерчлеес урьдчилан сэргийлэх, таслан зогсоо чиглэлээр хийсэн шинэлэг, үр дүнтэй нь туршлагаар батлагдсан ажил, арга барилын талаар мэдээлнэ.

Энэ мэдээллийг Аюулгүй байдал хариуцсан нэгжээс судалж, бусад байгууллага, нэгжид түгээх, нэвтрүүлэх арга хэмжээг авах ба энэ тохиолдолд мэдээлсэн байгууллага, нэгжийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг баримтлан урамшуулж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН САХИЛГЫН ЗӨРЧИЛ, ТҮҮНД ОНОГДУУЛАХ САХИЛГЫН ШИЙТГЭЛ

Арван хоёрдугаар зүйл. Алба хаагч хуулиар хүлээсэн
үүргээ үл биелүүлэх

12.1. Албан үүргээ биелүүлэх явцдаа хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, албаны нэр төрийг хүндэтгэн, өөрийгөө хэн болохыг танилцуулаагүй, хүнлэг энэрэнгүй харьцах үүргээ биелүүлээгүй бол учвал хүснэгийг даалгаж, сануулах шийтгэл оногдуулна.

12.2. Гүйцэтгэх ажлын тухай хууль, тогтоомж зерчсен нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, хуульд өөрөөр заагаагүй бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанц нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.3. Албан үүргээ гүйцэтгэхэд бусад хүн, албан тушаалтнаас нелөөлсөн дарамт шахалт, зохимжгүй нелөөллийн талаар дээд шатны удирдлагадаа мэдэгдээгүй үйлдэлд сануулах шийтгэл оногдуулна.

Тайлбар: Бусдын эрхшээл дарамт нь алба хаагчийг бие маход, сэтгэл зүйн хувьд гарцаагүй байдалд оруулсан болох нь тогтоогдвол шийтгэл ногдуулахгүй байж болно. Дарамт шахалтад орсон алба хаагчид удирдах албан тушаалтан,

хамт олон нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, шаардлагатай бол ажлын цагаар амрах боломжоо хангана.

12.4. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгээгүй бол зөрчлийн шинж байдлаас шалтгаалж сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зааснаар цагдаагийн байгууллагад даалгасан үүргийг биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.6. Шүүх, шуугчийн аюулгүй байдлыг хангах журам зөрчсөн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.7. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх талаар тогтоосон журам зөрчсөн бол зөрчлийн байдлаас шалтгаалж сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.8. Алба хаагчдыг олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах үүргээ биелүүлээгүй, хуулиар тогтоосон журам зөрчсөн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

12.9. Иргэн, хуулийн этгээд галт зэвсэг өмчлөх, ашиглах, галт зэвсэг, сум үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, зээмших журмын биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.10. Гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах журмын биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

12.11. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хулээн авч бүртгэх, хойшлуулшгүй арга хэмжээ авах, таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх, гэмт хэргийг илрүүлэх үүргээ биелүүлээгүй бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан, албаны нэр хүнд, иргэний эрх зөрчигдсөн бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.12.Хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.13.Хуулиар харьяалуулсан хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, заавар, зөвлөмжийг өгөх, биелэлтийг тооцох үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтанд сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.

12.14.Алба хаагч ажил тасалсан, шууд удирдах албан тушаалтанд мэдэгдэлгүйгээр дур мэдэн ажлын байраа орхин явсан бол сануулах, удаа дараа, эсхүл 5 хоногоос дээш тасалсан, бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.15.Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон үйл ажиллагааны журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.16.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.17.Цагдаагийн байгууллагын тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг зориулалтын бусаар ашигласан бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.18.Албан үүрэгтэйгээ холбогдолгуй асуудлаар нам, төрийн бус болон шашны байгууллагын үйл ажиллагаанд алба хаагчийн хувьд оролцсон бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.

12.19.Удирдлагааг зориуд буруу мэдээллээр хангасан бол сануулах, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

Арван гуравдугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хууль зерчих

13.1. Гэмт хэрэг, зерчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо буртгэл хетлех, лавлагaa гаргах журам зерчсэн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.2. Олон улсын цагдаагийн байгууллага (интерпол)-ын өмне хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн нийт байгууллагыг хангах үүргээ биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

13.3. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагааныхаа тайланг аймаг, нийслэлийн иргэд, оршин суугчдад, түүнчлэн тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагааныхаа тайланг тухайн нутаг дэвсгэрийн иргэдэд тавиагүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.4. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын удирдлага нь Цагдаагийн төв байгууллага болон харьялах Иргэний зөвлөлд ажлаа тайлагнах үүргээ биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.5. Удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгавар, тушаалыг хундэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шалтгааныг тогтоож, сануулах шийтгэл оногдуулна. Хэрвээ энэ зерчлийг давтан гаргасан, эсхүл зерчлийн улмаас байгууллагын үйл ажиллагаа тасалдаж хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах шийтгэл оногдуулна.

13.6. Нутгийн захирагааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргжлийн удирдлагаар хангах үүрэгтэй албан тушаалтан энэ үүргээ биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.7. Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал болон бусад объектыг хамгаалах, зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх үед үүргээ хангалтгүй биелүүлсэн бол сануулах, хор уршиг учирсан бол эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.8. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гол түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах үүргээ биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.9. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах үүргээ хангалтгүй биелүүлсэн бол сануулах, биелүүлээгүй бол албан тушаалын сарын үндсэн цалинг

3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.10. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, эд зүйлсийг эрэн сурвалжлаагүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.11. Алба хаагчдын өдөр тутмын ажилд хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, хүний эрх, эрх чөлөөг зөрчихеес урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авах үүрэгтэй албан тушаалтан энэ үргээ биелүүлээгүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.

13.12. Алба хаагч үүрэг гүйцэтгэх үед хэрэглүүлэхээр тавьж олгосон гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимыс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, агсамж ашиглах үндэслэл, журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийг давтан гаргасан, хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.13. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам зөрчсөн, мэдээллийн аюулгүй байдлыг алдагдуулсан, албаны мэдээллийг задруулсан бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.

13.14. Байгууллагын үйл ажиллагааг шуурхай, үр дунтэй явуулах шаардлагыг хангах төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулах, санал гаргах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй бол сануулах, уг зөрчлийг давтан гаргасан, байгууллагад хор уршиг учруулсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.15. Цагдаагийн цол, түүнийг таних тэмдгийг хууль бусаар хэрэглэсэн, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашигласан бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.16. Албан үргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан алба хаагчийг хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гутгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас алба хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг цагдаагийн байгууллагаар хамгаалуулах эрхийг нь хангаагүй бол сануулах, хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.17. Дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцэн үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг ханггуулах талаар ажлын байрны тодорхойлолтод заасан үргээ хангалтгүй биелүүлсэн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, биелүүлээгүй бол цагдаагийн цол бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.

13.18. Алба хаагчаар хуульд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлсэн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

---оОо---